



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар

A/364

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн 3.2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх болон өсвөр насны жирэмсэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/, Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

• 141201906

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06  
дугаар сарын 30-ны өдрийн А.364  
дугаар тушаалын хавсралт

## НЭГ. ОХИДОД ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨВӨРМӨЦ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

### 1.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Охидын нас, өсөлт, хөгжлийн онцлог, тулгамдсан асуудлыг харгалзан асуумж цуглуулж, нөхөн үржихүйн эрхтний үзлэг, шинжилгээ, оношилгоог хийнэ.

Охидын нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны хөгжлийн онцлогтой холбоотойгоор дараах насны үечлэлээр ангилдаг.

- Нярай үе /эхийн дааврын нөлөөтэй үе, ялангуяа төрсний дараах эхний 10 хоног/
- Хүүхэд үе: 8 хүртэлх нас /дааврын нөлөөгүй үе/
- Бэлгийн бойжилтын үе: 8-19 нас

#### Нярай үе

Эхээс дамжсан эстроген дааврын нөлөөгөөр төрсний дараах эхний 10 хоногт охидын хөхний булчирхай болон бэлэг эрхтэнд дараах шинж тэмдэг илэрдэг. Үүнд:

- Гадна бэлэг эрхтэн, үтрээний үүдэвч орчмын салст хөхөлбөр туяатай, хөөнгө болох;
- Үтрээнээс өтгөн салиархаг ялгадас гарах;
- Зарим тохиолдолд хөх бага зэрэг томорч, хөхний нөсөөт хэсгийн нөсөөжилт нэмэгдэж, сүүжих;
- Ховор тохиолдолд үтрээнээс үзэгдэх төдий цус гарна. Ихэвчлэн 5-8 дахь хоногт цусархаг ялгадас гарна. 3-4 дэх хоногт цус гарахыг эрт цус гаралт гэх ба харьцангуй удаан хугацаатай үргэлжилж болно. Нийт гарах цусны хэмжээ 2-3 мл-ээс хэтрэхгүй, 1-4 хоног үргэлжилнэ. Цус алдалтын хэмжээ их, үргэлжлэх хугацаа урт байвал цус алдах бусад шалтгаан байгаа эсэхийг шинжилнэ.

#### Хүүхэд үе

Нярай үе дууссанаас бэлгийн бойжилт эхлэх үе хүртэл үргэлжилнэ. Энэ үеийг “Дааврын нөлөөгүй үе” гэдэг. 2 хүртэлх насанд шар биеийн даавар нэг түвшинд байж, түүний хажуугаар бага зэрэг эстроген ялгардаг, үүнтэй холбоотой хөхний булчирхай бага зэрэг томрох ба хэсэг хугацааны дараа хэвийн болно. Умай хэвлийн хөндийд байснаа 4 настайд аарцгийн хөндийд бууна.

#### Бэлгийн бойжилтын үе

Энэ үед 8-19 насыг хамруулна. Нөхөн үржихүйн эрхтэн тогтолцоо хөгжиж гүйцнэ. Өсөлт эрчимтэй явагдаж, бүх эрхтэн тогтолцоо хөгжинө. Бэлгийн бойжилтын үеийг 3 шат болгоно.

#### Нэгдүгээр шат буюу бэлгийн бойжилтын урьдал үе:

Энэ үед 8-10 хүртэлх насыг хамруулна. Охидын харааны товгорын хөгжил гүйцээгүй, гонадотропин-рилизинг дааврын ялгарал тогтворгүй, дунджаар 5-7 хоногт нэг удаа ялгарч эхэлнэ. Гонадотропин-рилизинг дааврын нөлөөгөөр өнчин тархинаас гонадотропин дааврууд (ФСГ, ЛГ) ялгарна. Өндгөвчинд фолликул бэлтгэгдэнэ. Энэ үед зарим охидын хөхний булчирхай томорч эхэлнэ. Эхний үед хөхний нөсөөт хэсгээр



хатуувтар, хүрэхэд эмзэглэлтэй байх ба аажимдаа зөөлөрч, эмзэглэлгүй болно. Хөхний булчирхай томрохыг "Телархе" гэнэ.

Хоёрдугаар шат буюу бэлгийн бойжилтын эхний үе:

Энэ үед 10-13 насыг хамруулна. Охидын харааны товгорын үйл ажиллагаа тогтмолжиж, гонадотропин-релизинг дааврын ялгарал хоногийн мөчлөгтэй болох ба өнчин тархинаас ялгарах гонадотропин даавруудын (ФСГ, ЛГ) түвшин цусанд нэмэгдэхийн хирээр өндгөвчийн үйл ажиллагаа идэвхжиж, фолликул боловсорно. Өндгөвчөөс ялгарах эстроген дааврын нөлөөгөөр үтрээний салст бүрхэвч олон давхраатай болж, лактобацилл үүсч, үтрээнээс ялгарах хэвийн цагаан юмны хэмжээ ихэснэ. Умдганд үс ургаж эхлэх ба үүнийг "Пубархе" гэнэ.

Өндгөвчийн хөгжил 11-12 насанд эрчимжинэ. Өндгөвч, бөөрний дээд булчирхайн даавруудын нөлөөгөөр бэлгийн хоёрдогч шинж тэмдгүүд илэрнэ. Хөхний булчирхай томорч эхэлснээс хойш дунджаар 1-1,5 жилийн дараа анхны биений юм ирнэ. Бэлгийн бойжилтын хоёрдугаар үе нь анхны биений юм ирснээр дуусна. Анхны биений юмыг "Менархе" гэнэ. Эхний 2 жилд өндгөвчөөс өндгөн эс гадагшлахгүй, биений юм нэг мөчлөгтэй байж болно.

Гуравдугаар шат буюу бэлгийн бойжилт гүйцэх үе:

Энэ үед 14-19 насыг хамруулна. Охидын гонадотропин-релизинг даавар цагийн мөчлөгтэйгээр тогтмол ялгарна. ФСГ, ЛГ даавруудын огцом ялгаралт үүсч, өндгөн эс гадагшилж, биений юм хоёр мөчлөгтэй болно.

- Хөхний булчирхай хөгжиж гүйцнэ.
- Умдагны үсжилт гүйцнэ.
- Биений галбир насанд хүрсэн эмэгтэйтэй адил болно.

Анхны биений юм ирснээс хойш 3-4 жилийн дараа нөхөн үржихүйн эрхтэн тогтолцооны хөгжил бүрэн гүйцнэ.

**1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЯВЦАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

- Үйлчлүүлэгчийг ганцаарчлан ярилцах боломжоор хангана.
- Үйлчүүлэгчид хүндэтгэлтэй хандана.
- Шүүмжлэх, буруутгах хандлага гаргахгүй.
- Өмнөөс нь шийдвэр гаргахгүй, албадахгүй.
- Үйлчлүүлэгчийн бүртгэл, мэдээлэл, ярилцлагын тэмдэглэлийн нууцлал, аюулгүй байдлыг хадгална.
- Зайлшгүй мэдээлэх, мэдэх шаардлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчаас бусад хүнд үйлчлүүлэгчийн тухай мэдээллийг өгөхгүй.

**1.3. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ОРЧИН**

- Ярилцлага хийх, асуумж авах, зөвлөгөө өгөх, үзлэг хийх өрөө нь хүлээлгийн өрөөнөөс тусдаа, хүлээж буй хүмүүс тусламж, үйчилгээний явцыг харах, яриаг сонсох боломжгүй байх;
- Ганцаарчлан ярилцах, үзлэг хийх, зөвлөгөө өгөх боломжтой байх;
- Байгалийн гэрэл сайтай өрөө байх;
- Өрөө дулаан, цэвэр, аюулгүй (халдварын сэргийлэлт, хяналтын журмыг баримтлах).



#### 1.4. АСУУМЖ АВАХ

- Бага насны охины эцэг, эх, асран хамгаалагчаас асуумж авна.
- Өсвөр насны охины хувьд ярилцлага авах үед хэнтэй байхыг өөрөөс нь асууна.

#### 1.5. НEEADSSS ҮНЭЛГЭЭ

Охидтой, ялангуяа өсвөр насныхантай НEEADSSS аргаар нийгэм-сэтгэл зүйн байдлыг үнэлэх ярилцлагыг хийнэ.

Ярилцлагын явцад охидын өсөлт хөгжил, нийгэм, сэтгэл зүйн байдал, эрсдэлт зан үйлийг үнэлнэ.

Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орсон, жирэмсэн, жирэмсэн байж болох, бэлгийн замаар дамжих халдвар /БЗДХ/, хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй, амиа хорлох бодол, оролдлого, хорт бодисын хэрэглээ зэрэг өгүүлэмжтэй зэрэг эрсдэлийг тооцож, өндөр эрсдэлтэй гэж үзвэл эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн, хуулийн болон хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээнд холбох, хамтран ажиллах шаардлагатай болно.

НEEADSSS аргаар нийгэм-сэтгэл зүйн байдлыг үнэлэхдээ доорх хүснэгтийг ашиглан тэмдэглэл хийнэ.

НEEADSSS үнэлгээ				
Ярилцлага		Үнэлгээ		
		Хамгаалагдсан	Эрсдэлтэй	Эрсдэл өндөр
H(Home)	Гэр бүл, гэр орон			
E (Education)	Боловсрол/ажил			
E (Eating)	Хооллолт			
A (Activity)	Чөлөөт цаг			
D (Drug)	Хорт бодисын хэрэглээ			
S (Sexuality)	Бэлгийн амьдрал			
S (Suicide)	Амиа хорлох бодол/ оролдлого			
S (Safety)	Аюулгүй байдал			

Доорх шалгууруудын аль нэг нь байгаа бол ЭРСДЭЛ ӨНДӨР гэж үнэлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлээд, шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусламж, бусад мэргэжлийн тусламж үйлчилгээнд холбон зуучилна.

1. Хүүхдэд биемахбодод ноцтой гэмтэл бэртэл илэрсэн;
2. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн эсхүл өртсөн байж болзошгүй;
3. Гэр бүлд нь хүүхдэд анхаарал, халамж тавьж байгаа хүн байхгүй;
4. Хүүхэд тусгай хэрэгцээтэй бөгөөд гэр бүлд нь хүүхдэд анхаарал, халамж тавьж байгаа хүн байхгүй;
5. Хүүхдийн ЭЦЭГ, ЭХ, асран хамгаалагч, харгалзан ДЭМЖИГЧ мансууруулах бодис, архины хамааралтайн улмаас хүүхдэд анхаарал, халамж тавихгүй;



6. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч сэтгэцийн эмгэгийн улмаас бусдын болон өөрийн амь насанд аюултай үйлдэл хийж байсан;
7. Хүүхдийн эрүүл мэнд, амь насанд ноцтой хохирол учруулж болзошгүй бусад хүчин зүйл байгаа;
8. Өмнө нь энэ хүүхдийн хамгааллын талаар зөрчил гарч байсны улмаас холбогдох байгууллагуудад хандаж үйлчилгээ авч байсан;

Доорх шалгууруудын аль нэг нь байгаа бол ЭРСДЭЛТЭЙ гэж үнэлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлээд, шаардлагатай бол төрөлжсөн мэргэшлийн тусламж, бусад мэргэжлийн тусламж үйлчилгээнд холбон зуучилна.

1. Хүчирхийллийн улмаас хүүхэд гэрээсээ зугтаж, оргож байсан;
2. Хүүхэд амиа хорлох, биеэ гэмтээх оролдлого хийж байсан;
3. Хүчирхийлэгч нь хутга, мэс, зэвсгийн чанартай зүйл ашиглан хүүхдийг айлган сүрдүүлдэг;
4. Хүчирхийлэгч нь хүүхдийг бусдаас тусгаарлах, хорих зэрэг үйлдэл гаргасан;
5. Хүүхэд сургууль завсардсан;
6. Хүүхэд ажиллуулахыг хориглосон хүнд хөдөлмөр эрхэлдэг;
7. Хүүхэд гэмт хэрэгт холбогдсон;
8. Хүүхэд өнчирч асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгож амжаагүй.

## 1.6. ҮЗЛЭГ ХИЙХ

Үзлэг хийхдээ бага насны охидын хувьд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр, өсвөр насны охидын хувьд өөрсдийнх нь зөвшөөрснөөр сайн дурын үндсэн дээр хийнэ. Үзлэгийн өмнө үзлэг хэрхэн хийх, биеийн ерөнхий үзлэг, хөхний болон нөхөн үржихүйн эрхтний тусгайлсан үзлэг хийхийн ач холбогдол зэргийг тайлбарлана.

Үйлчлүүлэгч зөвшөөрөөгүй тохиолдолд тусгайлсан үзлэг хийхгүй.

### 1.6.1. Үзлэг хийх үед анхаарах зүйлс

- Үзлэгийн туршид "Үйлчлүүлэгч төвтэй" халамж тавьж, үйлчлүүлэгчтэй харилцан ярилцаж байх;
- Тав тухтай байгаа эсэхийг нь үе үе асууж, үзлэгийн үед гэнэт өвдөх, таагүй байдал мэдэгдвэл хэлэхийг хүсэх;
- Үйлдлийнхээ өмнө юу хийх гэж буйгаа хэлж мэдэгдэх;
- Хэвийн байгаа болгоныг "хэвийн", "эрүүл", "сайн" гэх мэтээр хэлж байх;
- Эмнэлгийн үг хэллэг аль болох хэрэглэхгүй байх.

### 1.6.2. Ерөнхий үзлэг

Ерөнхий үзлэгийг зааврын дагуу хийх ба дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн хөдөлгөөн чөлөөтэй эсвэл хязгаарлагдмал эсэхийг харж ажиглана;
- Үзлэгийн эхэнд үйлчлүүлэгчийн биеийн жин, урт/өндрийг хэмжиж, өсвөр насны охидод биеийн жингийн индексийг тооцож үнэлнэ;
- Нярай болон хөлд ороогүй охидыг хэвтүүлж, хөлд орсон цагаас охидыг зогсоо байрлалд нүцгэнээр биеийн ерөнхий галбир, цээж, гар, хөл, үенүүдийн хэлбэр, булчингийн хөгжил, биеийн хоёр тал тэгш хэмтэй эсэхийг харж үнэлнэ;
- Арьсны өнгө, арьсан доорхи өөхөн эдийн хөгжил, булчингийн хөгжил, арьсанд тууралт, хөхрөлт, няцралт, шарх, шархлаа, сорви зэрэг өөрчлөлтүүдтэй эсэхийг харж ажиглана. Эмч дулаан, хуурай, цэвэр гараар арьсны уян чанар, чийглэг байдал, арьсны хэм, хавантай эсэхийг шалгана.
- Өсвөр насныханд сколиоз (нуруу хажуу тийш муруйх) үүсэх эрсдэлтэй тул дараах аргуудаар харж шалгана.



- Үйлчлүүлэгчийг тэгшхэн зогсоогоод араас нь харахад хоёр мөр нэг түвшинд байгаа эсэх;
  - Хоёр далны өнцөг нэг түвшинд эсэх. Муруйлт үүссэн тохиолдолд муруйлт үүссэн талын дал түлхэгдэн, өнцөг нь нөгөө далныхаас дээр байрлаж харагдана;
  - Хүүхдийг тонгойлгоод, хоёр гарыг нь доош нь унжуулаад нурууны арын сэртэн голын шугамын дагуу тэгш байгаа эсэх;
- Хэвлийн тэмтрэлт: Үйлчлүүлэгчийг үзлэгийн орон дээр дээш харуулан хэвтүүлээд, нийт хэвлийг өнгөц, гүн тэмтрэлт хийж шалгана. Эмзэглэлтэй эсэх, хэвлийн булчингийн чангарал, ямар нэгэн үүсгэвэр тэмтрэгдэж буй эсэхийг шалгана.

### **1.6.3. Хөхний эмнэлзүйн шинжилгээ**

#### **1.6.3.1. Ерөнхий зүйл**

Охидод хөхний эмнэл зүйн шинжилгээг урьдчилан сэргийлэх болон зовуурь, өвчний шалтгааны улмаас хийж болно. Хөхний эмнэл зүйн шинжилгээгээр хөхний хөгжил, хэвийн бус байдал, өвчин эмгэгийг илрүүлэх боломжтой. 20 наснаас хөхний эмнэл зүйн шинжилгээнд тогтмол хамрагдаж эхэлнэ.

Хөхний эмнэл зүйн шинжилгээ нь охидод хийх тусгайлсан үзлэгийн бүрэлдэхүүн хэсгийн нэг болно.

Хөхний эмнэл зүйн шинжилгээ нь харж ажиглах, тэмтрэх аргаар хийгдэх ба охиныг зөв байрлуулж, үзлэгийг дулаан гараар нягт нямбай, болгоомжтой хийнэ.

#### **1.6.3.2. Нярай болон бага насны охидод хөхний эмнэлзүйн шинжилгээ хийх**

Нярайг эхээс төрмөгц төрөх өрөөнд нярайн болон хүүхдийн эмч хөхний анхны үзлэг хийнэ. Нярайд үзлэг хийх үед хөхний байрлал, хэмжээ, нэмэлт хөхтэй эсэх, хөхний толгойноос ялгадас гарч буй эсэх, орчны тунгалгийн булчирхай зэргийг харж, тэмтэрч шалгана.

Нярайд (охид, хөвгүүдэд) эхээс дамжсан бэлгийн дааврын нөлөөгөөр хөх томрох, сүүжих шинж илэрч болно.

#### **1.6.3.3. Өсвөр насны охидод хөхний эмнэлзүйн шинжилгээ хийх аргачлал**

Өсвөр насны охидод үзлэг хийхдээ бэлгийн бойжилтын зэргийг үнэлнэ. Бэлгийн бойжилт ихэнх охидод хөхний хөгжлөөр эхлэх ба 8-13 насанд, дунджаар 10.3 насанд эхэлнэ. Хөхний хөгжил дунджаар 4.2 жил үргэлжилдэг. Охидод хөхний эмгэг ховор тохиолддог ч хөхний хөгжил нь өсвөр насны охидын сэтгэл зүйн байдалд нөлөөлдөг.

Өсвөр насны охидод үзлэг хийх үедээ өөрөө хөхөө шалгах аргыг зааж сурган, хөхний эмнэл зүйн шинжилгээнд хамрагдаж байх талаар мэдээлэл өгнө.

#### **Хөхийг харж ажиглах**

Үйлчлүүлэгчийг зогсоо байрлалд хөхийг харж шалгана. Эхлээд 2 гарыг доош унжуулж, дараа нь 2 гарыг толгой дээр нь өргүүлж, мөн 2 гараа ташаандаа авч, гараар ташаандаа хүчтэй тулах байрлалд урагш бөхийлгөн дараах байдлуудыг харж ажиглана.

- Хөхний хэлбэр дүрс, тэгш хэмтэй эсэх;
- Хоёр хөх хэмжээгээрээ ижил байгаа эсэх. Өсвөр насны зарим охидод хоёр хөх хэмжээгээр бага зэрэг өөр байж болно;



- Хөхний арьсны өнгө;
- Хөхний арьс дотогш татагдаж, хонхойсон эсэх;
- Хөхний нөсөөт хэсэг, товчны байдал;
- Хөхнөөс ялгарал гарч буй эсэх.

### **Хөхийг тэмтэрч шалгах**

Үйлчүүлэгчийг тэгш, хатуу орон дээр хэвтүүлж, хөх, орчны тунгалгийн булчирхайг тэмтэрч шалгана. Эгэмнээс хөхний доод тал хүртэл, суганы дунд шугамнаас өвчүү хүртэл хөхийг бүхэлд нь, орчны тунгалгийн булчирхай, сугыг хамруулан шалгана. Хэсэг тус бүрийг 3 удаа тэмтэрч шалгана. Эхний удаа хөнгөн, хоёр дахь удаа дунд, гурав дахь удаа хүчтэй дарж тэмтрэлтийг гүйцэтгэнэ.

Босоо шугамын дагуу, цацраг хэлбэрээр, эсвэл тойрог хэлбэрээр тэмтэрч шалгаж болно.

Хөхийг 2,3,4-р хурууны алган талын гадаргуугаар тэмтэрч шалгана. Хурууны хооронд хөхийг хавчихгүй байхаар шалгана.

Босоо шугамын дагуу тэмтэрч шалгах: Эгэмнээс хөхний доод нугалаас хүртэл дээрээс доош, доороос дээш чиглэлд тэмтэрч, 2 хөхийг бүхэлд нь шалгана.

Цацраг хэлбэрээр шалгах: хөхийг бялуу хуваадаг шиг хэрчмүүдэд хувааж, хэрчим тус бүрийг гаднаас хөхний товч руу чиглүүлэн тэмтэрч, 2 хөхийг бүхэлд нь шалгана.

Тойрог хэлбэрээр тэмтэрч шалгах: Хөхний товч орчмоос эхлэн цагийн зүүний эргэлтийн дагуу товчийг тойруулан, тойргийн хэмжээг аажмаар нэмэх замаар тэмтэрч, 2 хөхийг бүхэлд нь шалгана.

Хэвийн бус өөрчлөлт илрүүлбэл нөгөө хөхний ижил хэсгийг харьцуулан тэмтрэх, нэмэлт шинжилгээ хийх шаардлагатай.

Орчны тунгалгийн булчирхайг шалгахдаа томролт ба эмзэглэл байгаа эсэхийг үзнэ.

#### **1.6.4. Нөхөн үржихүйн эрхтний тусгайлсан үзлэг**

Охидын нас, биеийн болон бэлгийн хөгжлийн онцлогт тохирсон үзлэг хийнэ.

Охидын нөхөн үржихүйн эрхтний тусгайлсан үзлэг нь дараах үзлэг, шинжилгээнээс бүрдэнэ.

- Гадна бэлэг эрхтний үзлэг
- Дотор бэлэг эрхтнийг шинжлэх (Зөвхөн шаардлагатай тохиолдолд өсвөр үеийн болон эмэгтэйчүүдийн эмч үзлэг хийнэ).
  - Үтрээнд толь тавьж шинжлэх
  - Үтрээний буюу хоёр гарын хавсарсан үзлэг
  - Шулуун гэдэсний үзлэг (хошноогоор үзэх)
- Багажийн шинжилгээ

##### **1.6.4.1. Нярай болон бага насны охидод үзлэг хийх**

Нярайн гадна бэлэг эрхтний хөгжлийг үнэлэх анхны үзлэгийг төрөх өрөөнд хийнэ.

Нярай болон бага насны охидод зонхилон тохиолддог доорх зовуурь, шалтгаануудын улмаас нөхөн үржихүйн эрхтний тусгайлсан үзлэг хийнэ. Ихэвчлэн зөвхөн гадна бэлэг эрхтний үзлэг хийнэ.



- Гадна бэлэг эхтний хөгжил хэвийн бус;
- Үтрээ, гадна бэлэг эрхтэн улайх;
- Гадна бэлэг эрхтэн орчимд загатнах, хорсох, өвдөх;
- Үтрээнээс ялгадас гарах;
- Бэлгийн уруулууд наалдах;
- Гадна бэлэг эрхтэн, үтрээнээс цус гарах;
- Гадна бэлэг эрхтэн орчимд шарх, шархлаа, тууралт гарах;
- Цавины булчирхай томрох, өвдөх;
- Үтрээнд гадны биет орсон байж болох;
- Хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй өгүүлэмж;
- Гадна бэлэг эрхтэн орчмын механик гэмтэл, түлэгдэл;
- Бэлгийн эрт бойжилт;
- Нөхөн үржихүйн эрхтний хоргүй, хортой хавдар.

#### 1.6.4.2. Өсвөр насны охидод үзлэг хийх

##### Гадна бэлэг эрхтний үзлэг

- Үйлчлүүлэгчийг давсгаа суллахыг хүсч, бэлхүүснээс доошхи хувцсаа тайлаад үзлэгийн орон дээр хэвтэхийг хүснэ. Үйлчлүүлэгчийн биеийн бусад хэсгийг бүтээлгээр хучвал тохиромжтой;
- Эмч хоёр гараа мөрний хэмжээнд байрлуулж, үйлчлүүлэгчийг хоёр хөлөө эмчийн 2 гарт хүртэл салгаад, зориулалтын тавиур дээр тахимаар тавихыг хүснэ;
- Гадна бэлэг эрхтэн орчим, умдаг, цавь, гуяны дотор тал, хярзан, хошногоны хуниас, хошног орчмын арьс, умдагны үсжилт зэргийг харж ажиглана;
- Шарх, шалбархай, тууралт, үрэвсэл болон хөхрөлт, гэмтэл байгаа эсэх, хэрэв байвал хэлбэр, хэмжээ, өнгийг ажиглана;
- Үтрээний үүдэвч орчмын салст хэвийн эсэх, үтрээнээс ялгадас гарч буй эсэх, ялгадас гарч буй бол өнгө, хэмжээ, бүтэц, үнэр зэргийг ажиглана;
- Умдаг, бэлгийн их уруулыг зөөлөн тэмтэрч шалгана;
- Цавины орчмоор тэмтрэн, тунгалгийн булчирхай томорсон эсэх, эмзэглэлтэй эсэхийг шалгана;
- Бэлгийн зүүн их уруулыг эмч баруун гарынхаа эрхий долоовор хуруугаар, баруун их уруулыг зүүн гарынхаа эрхий долоовор хуруугаар бариад өөр рүүгээ, бага зэрэг дээшээ чиглэлд зөөлөн татаж, гадна бэлэг эрхтний хөгжил зөв эсэхийг харна.

##### Үтрээнд толь тавьж шинжлэх

Зөвхөн шаардлагатай үед (бэлгийн хавьталд орсон бол) үтрээнд толь тавьж шинжилнэ. Нэг удаагийн толь хэрэглэнэ. Эхлээд зүүн гарын долоовор хуруугаа үтрээнд оруулаад үтрээний үүдэвч орчимд бага зэрэг доошоо алгуурхан дарж, булчин сулрахыг хүлээгээд, баруун гараараа толины хавтсыг хаалттай байдлаар барьж, 45 хэмийн налуугаар үтрээнд хийнэ. Толийг үтрээнд хийх үед зүүн гараа үтрээнээс авна. Толины талыг үтрээнд оруулаад эргүүлж, бариулыг доош харсан байхаар байрлуулаад бүрэн шургуулна. Хавтсуудыг болгоомжтой тэлж, толийг болгоомжтой хөдөлгөн умайн хүзүүг олоод, толио түгжиж бэхлэн, умайн хүзүүний байдал, үтрээний



хана, ялгадасны байдлыг хараад толины түгжээг мултлан, хавтсыг хаагаад үтрээнээс сугалж авна.

### **Үтрээний буюу хоёр гарын хавсарсан үзлэг**

Үтрээний буюу хоёр гарын хавсарсан үзлэгийг зөвхөн шаардлагатай үед хийнэ (бэлгийн хавьталд орсон охидод). Аарцгийн хөндийн эрхтнийг тэмтэрч шинжилнэ. Гарын долоовор, дунд хурууг үтрээнд оруулаад алгаа дээш харуулна. Дараах зүйлсийг үзнэ.

- Үтрээ бачуу, уужим эсэх, үтрээний ханын байдал;
- Умайн хүзүүг тэмтрэн хэлбэр, цуллаг байдлыг тодорхойлно;
- Умайн хүзүүг хөдөлгөж, эмзэглэлтэй эсэхийг тодруулна. Хурууны завсарт умайн хүзүүг хавчин, охины нүүрний хувирлыг ажиглангаа хөдөлгөнө. Ингэхэд эмзэглэлтэй байх нь умай, дайврын үрэвсэлтэйг илтгэж болно. Умайн хүзүү зөөлөн байвал жирэмсэн байж болзошгүйг анхаарна;
- Умайн байрлал, хэлбэр, хэмжээ, цуллагийг шалгана;
- Хэвлийн доод хэсэгт эмч нөгөө гарын хуруугаар зөөлөн дарж, умайг доторхи ба гаднах хуруунуудын хооронд тэмтэрч шалгана. Үүний дараа баруун, зүүн дайврыг ээлжлэн тэмтэрнэ. Дайврууд хэвийн үед тэмтрэгдэхгүй байж болно.

Үтрээнээс гараа авч үзлэгийг дуусгана. Урьдчилсан оношоо тавьж, шаардлагатай шинжилгээг төлөвлөнө.

### **Шулуун гэдэсний үзлэг (хошноогоор үзэх)**

Охидод хэвлий, шулуун гэдэсний хавсарсан үзлэгийг хийнэ. Хүүхдийн нас ахих тутамд үзлэг хийхэд хялбар байх болно. Бага насны хүүхдэд шулуун гэдэсний үзлэг хийх бол унтуулгатай хийнэ.

- Шулуун гэдэсний үзлэгийг хийх заалт нь үтрээний гаж хөгжил ба сорвижилттой эсвэл охин хальс сэвтээгүй байх;
- Охидын бэлэг эрхтний эмгэг байдлыг ирүүлэх, оношлох зорилгоор хийнэ;
- Үзлэгийн өмнө охинд болон эцэг эх, асран хамгаалагчид шулуун гэдсээр үзлэг хийх нь ямар нэгэн сөрөг нөлөөгүй, айх хэрэггүй гэдгийг тайлбарлан ойлгуулна;
- Үзлэг хийхдээ охиныг үзлэгийн орон дээр гаргаж гадна бэлэг эрхтэн, хошноого орчмыг халдваргүйжүүлэгч уусмалаар арчина;
- Хошноогоор хуруу оруулахад өвтгөхгүйн тулд бээлий болон хуруувчинд вазелин эсвэл гель түрхэж үзлэг хийнэ;
- Хэвлий, шулуун гэдэсний хавсарсан үзлэгээр умайн хэлбэр, хэмжээ, эмзэглэл, бага аарцгийн хөндийд ямар нэг өөрчлөлт байгаа эсэхийг тодруулна.

### **ШИНЖИЛГЭЭ**

Охидод оношилгоо, эмчилгээний арга хэрэгслийг ашиглах нь хязгаарлагдмал байдаг. Шаардлагатай тохиолдолд дараах шинжилгээнүүдийг хийж болно.

#### Чанд авиа

Умай, өндгөвчийн хэмжээ, байрлал, бүтэц, хэлбэр, умайн салстын зузаан, умайн гажиг хөгжлийг тодорхойлох зорилгоор хийнэ.

#### Рентген шинжилгээ

Рентген шинжилгээгээр турк эмээлийн хэлбэр, хэмжээ (босоо, хөндлөн), бүтцийг тодруулна. Турк эмээлийн өндөр, уртын харьцааг "Турк эмээлийн индекс" гэнэ.



Хүүхдийн биеийн өсөлттэй холбоотой “Турк эмээлийн индекс” өөрчлөгдөж байдаг. Бага насны хүүхдэд “Турк эмээлийн индекс” 1 нэгжтэй тэнцүү буюу их байдаг бол бэлгийн бойжилтын үед 1 нэгжээс бага байна.

#### Үтрээ дурандах (Вагиноскопия)

Уретроскоп ашиглан үтрээний салст бүрхэвч, умайн хүзүүг томруулан харж оношилдог багажийн шинжилгээ юм. Гэмтэл, умайн хүзүүний хавдар, полип, үтрээнд гадны биет орсон үед голчлон хэрэглэнэ.

#### Үтрээ зондлох

Үтрээний уртыг хэмжих, гажиг хөгжлийг оношлох, үтрээнд гадны биет орсон үед энэ аргаар шинжилнэ. Зондны тусламжтайгаар үтрээнд буй гадны биетийг авч болно.

#### Сорилын хатгалт

Охин хальс битүү гаж хөгжилтэй үед биений юм үтрээнд саатаж цус хуримтлагдсаныг тогтоох зорилгоор хатгалт хийнэ. Хэсэг газрын мэдээгүйжүүлгийн дор хатгалт хийхэд цус гарч байвал энэ нь охин хальсыг нээж, үтрээнд гарц гаргах хагалгааны эхний шат болно.

#### Гистерография

Тодосгогч бодис уротраст, верографин, веротраст ашиглаж хийнэ. Умайн хөндийн хэмжээ, хэлбэр, умайд үүсгэвэр (хавдар, полип) байгаа эсэх, умайн гаж хөгжлийг (эвэр хэлбэрийн, эмээл хэлбэрийн таславчтай гэх мэт) оношлох ач холбогдолтой.

Өсвөр насанд умайн их бие, умайн хүзүүний харьцаа 2:1 байвал хэвийн, 1:2 байвал бэлгийн бойжилт саатах (биений юм ирэхгүй) шалтгаан болно.

#### Умайн хөндийгөөс аспирац авах

Умайн цус алдалтын үед голчлон хийнэ.Эндометрийн бүтцийг үнэлэх оношилгооны зорилгоор болон эмчилгээний зорилгоор хийнэ. (Ажилбарын талаар урьдчилж сайтар тайлбарлаж хэлнэ.)

#### Цитогенетикийн шинжилгээ

Бэлгийн булчирхайн төрөлхийн гажгийг оношлох зорилгоор хийнэ. Хацрын дотор талын салстаас наалдац авч, өнгөн давхаргын эсийн цөмд бэлгийн хроматин тодорхойлно. Хэвийн тохиолдолд хроматин 16-28% байна.

#### Кариотип шинжлэх

Хромосомын тоо, бүтцийг тодорхойлох зорилгоор хийнэ.

#### Кольпоцитологийн шинжилгээ

Үтрээний хажуугийн хүнхрээнээс наалдац авч, үтрээний шингэний эсийн бүтцийг судлах ба нөхөн үржихүйн тогтолцооны үйл ажиллагааны эмгэгийг (эстрогены хангалт) оношлох, даавар эмчилгээний үр дүнг үнэлэх зорилгоор хийдэг. Биений юмны мөчлөгийн явцад хэд хэдэн удаа авна.

#### Компьютер томография

Толгой, хэвлий, аарцгийн эрхтний эмгэгийг оношлох зорилгоор хийнэ.

#### Лабораторийн шинжилгээ

- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- Шээсний ерөнхий шнжилгээ
- Биохимийн шинжилгээ
- Дааврын шинжилгээ
- Үтрээний ялгадаснаас нян илрүүлэх



- Үтрээний ялгадаснаас нян өсгөвөрлөх
- Шимэгч хорхой илрүүлэх
- Серологи, PCR
- Вирус судлал

## **1.8. ОХИДОД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭР**

### **1.8.1. Урьдчилан сэргийлэх**

- Зөвлөгөө, мэдээлэл өгөх
- Үзлэг, шинжилгээ хийх
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ (эрүүл мэндийн боловсрол олгох албан бус сургалт)

### **1.8.2. Амбулаторийн тусламж, үйлчилгээ**

- Үзлэг
- Оношилгоо
- Эмчилгээ

### **1.8.3. Эмнэлэгт хэвтүүлэн оношлох, эмчлэх**



## **ХОЁР.ӨСВӨР НАСНЫ ЖИРЭМСЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР**

### **2.1. ҮНДЭСЛЭЛ**

- 2.1.1. Энэхүү зааврын зорилго нь өсвөр насныханд үзүүлэх эрүүл мэндийн болон сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, өсвөр насны жирэмснийг (цаашид үйлчлүүлэгч гэх) өөрсдийнх нь болон асран халамжлагчийн хүсэлтээр шинжлэх, оношлох, жирэмснийг шийдвэрлэх, үр хөндөлтийн өмнөх ба дараах цогц тусламж үйлчилгээ, жирэмсний хяналт, эсэн мэнд амаржих, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх, холбон зуучлах, тэдний хувийн нууцыг хуулийн хүрээнд чандлан хадгалахад оршино.
- 2.1.2. Энэхүү зааврыг үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар хэрэгжүүлнэ.
- 2.1.3. Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээ”, “Үр хөндөлтийн тусламж үйлчилгээ” MNS 5488:2019 Монгол улсын стандарт, Үр хөндөлтийг зохицуулах журмын дагуу үзүүлнэ.

### **2.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ дор дурдсан үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн эрх ашиг, хүний эрхийг дээдлэх;
- Жендерийн тэгш байдлыг хангаж ажиллах;
- Хувийн нууцыг хуулийн хүрээнд чандлан хадгалах;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь үйлчлүүлэгчид ээлтэй байх;
- Өсвөр үеийнхний оролцоонд тулгуурлах.

### **2.3. ӨСВӨР НАСНЫ ЖИРЭМСЭНД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

Өсвөр насны жирэмсэнд сэтгэхүйн болон бие бялдрын өөрчлөлттэй холбоотой өвөрмөц тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

2.3.1. Жирэмсэн болоход дараах зүйлийг нөлөөлсөн эсэхийг тодруулна:

- Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, мэдээлэл дутмаг (жирэмслэхээс сэргийлэх аргын талаар мэдлэггүй, дутмаг мэдлэгтэй);
- Бэлгийн хавьтлын талаар шийдвэр гаргах чадваргүй;
- Бэлгийн хавьтлын талаар ташаа ойлголттой;
- Тохиолдлын бэлгийн хавьталд орсон;
- Хүчирхийлэлд өртсөн.



2.3.2. Жирэмсэн болоход нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулна:

- Бэлгийн хавьталд эрт орох;
- Эрсдэлт зан үйл (мансууруулах бодис, хар тамхи, архины хэрэглээ, биеэ үнэлэх);
- Эрт гэрлэх, хамтран амьдрах;
- Хүүхэдтэй болохыг тулган шаардсан;
- Эдийн засгийн асуудал;
- Боловсролын түвшин.

#### **2.4. ЖИРЭМСНИЙГ ОНОШЛОХ АРГУУД**

2.4.1. Жирэмсний эрт илрэх шинжүүд: бөөлжис цутгах, шүлс гарах, аманд эвгүй амт амтагдах, хоолны дуршил муудах, их унтах зэрэг шинжүүд илэрч байгаа эсэхийг асууна.

2.4.2. Бодит шинжүүд: Биений юм хаагдах, хөх томрох, хөхний толгой харлах, хэвлий томрох, нүүр сэвхтэх зэрэг шинж байгаа эсэхийг үзлэгээр тогтооно.

2.4.3. Сорил тавих: шээсэнд жирэмсний сорил тавьж тодорхойлно.

2.4.4. Үзлэг хийх: Үзлэгээр жирэмснийг оношилж, хугацааг тодорхойлно.

2.4.4.1. Биеийн ерөнхий үзлэг

2.4.4.2. Тусгайлсан үзлэг: гадна бэлэг эрхтний үзлэг, үтрээнд толь тавьж шинжлэх ба үтрээний үзлэг хийнэ.

2.4.4. Чанд авиан шинжилгээ хийж, жирэмснийг баталгаажуулна.

Өсвөр насны жирэмснийг өндөр эрсдэлтэй жирэмсэнд тооцно.

#### **2.5. ЖИРЭМСЛЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

2.5.1. Үйлчлүүлэгч болон түүний зөвшөөрснөөр эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бэлгийн хостой нь хамтран ярилцаж, жирэмслэлтийг шийдвэрлэх талаар мэдээлэл өгч, дараах хувилбаруудаас сонголт хийлгүүлнэ.

- Эрт үеийн үр хөндөлт (өөрийн хүсэлтээр, эмнэлгийн заалтаар);
- Хожуу үеийн үр хөндөлт (өөрийн хүсэлтээр, эмнэлгийн заалтаар);
- Хүүхдээ тээж төрүүлэх

2.5.2. Үйлчлүүлэгч үр хөндөлт хийлгэхээр шийдсэн бол аймгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газарт “Үр хөндөлтийн тусламж үйлчилгээ” MNS 5488:2019 Монгол улсын стандарт, Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан “Үр хөндөлтийг зохицуулах журам”-ын дагуу тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.5.3. Жирэмснийг тээж төрүүлэх бол Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”, “Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлол”-ын дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

#### **2.6. ӨСВӨР НАСНЫ ЖИРЭМСЭН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХДЭЭ АНХААРАХ ЗҮЙЛ**

2.6.1. Биеийн өсөлт, хөгжил гүйцээгүй;

2.6.2. Сэтгэлзүйн асуудал (айдас; ичиж зовох, өөрийгөө буруутгах гэх мэт) тохиолдох эрсдэлтэй тул үйлчлүүлэгчтэй тайван, илэн далангүй, итгэл төрүүлэхээр, нууцыг хадгалсан, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхээр харилцана;



**2.6.3. Жирэмсэн, төрөлтийн дараах үед хүндрэлүүд гарах эрсдэлтэй.**

- Дутуу төрөх, ургийн хөгжил саатах;
- Ургийн буруу байрлал тохиолдох;
- Умайн цус алдалт;
- Ураг, эхсийн дутмагшил үүсч, эх дотор ургийн хөгжил саатах, ураг хүчилтөрөгчийн дутмагшилтэй байх;
- Жирэмсний хожуу үеийн хордлого;
- Цус багадалт;
- Төрөх үеийн хүндрэл.

**2.7. ТӨРӨХ ҮЕИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

Өсвөр насны жирэмсэн үйлчлүүлэгчийг төрөхөөр эмнэлэгт хандахад эелдэг, найрсаг хүлээн авч үйлчилнэ.

**2.7.1. Зөвлөгөө. Төрөлтийн туршид дараах зөвлөгөөг тогтмол өгнө.**

- Зөв амьсгалах (хамраар урт амьсгал авч, амаар аажим гаргах);
- Зөв байрлал (хоёр талаар ээлжлэн хэвтэх, боломжтой бол босч явах, 4 хөллөж хэвтэх, ор түшиж зогсох г.м);
- Зөв дүлэх (эмч, эх баригчийн үгийг сайтар сонсож, зөвлөмжийг дагахыг хэлэх);
- Төрөлтийн I үед шингэц сайтай хоол идэх, шингэн зүйл уухыг зөвлөнө.

**2.7.2. Төрөлтийн үеийн тусламж, үйлчилгээ**

**2.7.2.1. Төрөлтийн I үед:**

- Амин үзүүлэлтийг 2 цаг тутам хянах;
- Умайн базлалт хоорондын зай, базлалтын хүч, үргэлжлэх хугацаа, ургийн зүрхний цохилт, ургийн толгойн доошлолтыг хянах (партограм хөтлөх);
- Үтрээний үзлэгийг 4 цаг тутамд хийх.

**2.7.2.2. Төрөлтийн II үед:**

- Өсвөр насны төрөгчид төрөх хүчний үйл ажиллагаа хэт эрчимтэй явагдаж хурдан төрөх, төрөх хүчний сулрал, умайн хүзүү, хязан урагдах, ургийн толгойн хэмжээ тохирохгүй байх, цус алдах хүндрэл ихэвчлэн тохиолддогийг анхаарч, хүндрэлээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан бэлтгэнэ.
- Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан "Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй" удирдамжийн дагуу тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

**2.7.2.3. Төрөлтийн III үед:**

- Төрөлтийн III үеийг идэвхтэй удирдана.

**2.7.3. Нярайн эрт үед үзүүлэх тусламж, үйлчилгээ**

- Нярайг хуурайшуулах, арьс арьсаар шүргэлцүүлэх, малгай өмсгөх, хүйг зөв хугацаанд зөв хөндөнө;
- Нярайг 30 минут - 1 цагийн дотор амлуулж, ангир уургийг хөхүүлнэ;
- Нүдний сувилгаа хийнэ, "А" аминдэм булчинд тарина;



- Нярайн биеийн байдлыг үнэлэх, хянах, хүндрэлийг илрүүлж, эмчилнэ;
- Нярайг 24 цагийн дотор усанд оруулахгүй;
- Төрөх өрөөнд болон төрсний дараах өрөөнд эх, нярайг хамтад нь байлгана;
- Амьдралын эхний 24 цагийн дотор В гепатит, БЦЖ, саагийн эсрэг дархлаажуулалтыг хийнэ. (Дархлаажуулалт хийхийн өмнө эхэд мэдээлэл зөвлөгөө өгнө);

**2.7.4. Төрсний дараах үед:**

- Төрөлтийн талаар эх болон ар гэрийнхэнд мэдээлнэ;
- Ерөнхий биеийн үзлэг хийнэ;
- Төрсний дараах хүндрэлийг эрт илрүүлэх (халдвар, цус алдалт, цус багадалт, манас таталт) ба хүндрэлээс урьдчилан сэргийлнэ;
- Эхэд мэдээлэл, зөвлөгөө өгнө.

**2.7.5. Төрсний дараах үед эх, нярайд хамтад нь үзүүлэх тусламж, үйлчилгээ**

**2.7.5.1. Төрсний дараах үзлэг, гэрийн эргэлт;**

- Төрсний дараах 3 дахь хоногт гэрээр очиж тусламж, үйлчилгээ үзүүлнэ;
- Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй үзнэ;
- Эх, нярайг төрсний дараах 5-6 дахь 7 хоногт давтан үзнэ.

**2.7.5.2. Өсвөр насны эх ойрхон дахин жирэмслэх магадлал өндөр байдаг тулгэр бүл төлөвлөлтийн тохиромжтой арга сонгоход заавал тусална.**

**2.8. СЭТГЭЛЗҮЙН БОЛОН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

2.8.1. Үйлчлүүлэгчид сэтгэлзүйн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагын сэтгэл зүйчид холбон зуучилна.

2.8.2. Үйлчлүүлэгчид сэтгэцийн эмгэг, амиа хорлох бодол илэрсэн, оролдлого хийсэн, хийх эрсдэлтэй тохиолдолд сэтгэцийн эмчийн тусламж, үйлчилгээнд холбон шилжүүлнэ.

**2.9. НИЙГМИЙН АЖИЛТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ**

2.9.1. Эрүүл мэндийн нийгмийн ажилтны зөвлөгөө, тусламж;

2.9.2. Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээ;

2.9.3. Хөгжлийн нийгмийн ажилтны тусламж, үйлчилгээ.